



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 30 өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот

Г Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах Г
тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12 дах хэсэг, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Усны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. "Геодези, усны барилга байгууламжийн газар" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг хавсралтаар баталсугай.

2. Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль, журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж ажиллахыг "Геодези, усны барилга байгууламжийн газар" орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дарга (Л.Ариунтуяа)-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт гавьж ажиллахыг Хурлын Засаглал, эрх зүйн шинэтгэлийн хороо (Б.Мягмар)-нд даалгасугай.

4. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 14 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100545

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 03 сарын 30-ны өдрийн 26 дугаар
тогтоолын хавсралт

**"ГЕОДЕЗИ, УСНЫ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ГАЗАР"
ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗРЫН ДҮРЭМ**

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1."Геозези, усны барилга байгууламжийн газар" /цаашид "Газар" гэх/ нь Улаанбаатар хотыг үер, хур тунадасны болон хөрсний уснаас хамгаалах, нийтийн аж ахуй, барилга байгууламж, бохир усны төвлөрсөн цэвэрлэх байгууламж, хурын ус зайлуулах, шугам сүлжээний засвар, арчлалт, өрөмдмөл худаг гаргах, хөрсний болон гадаргын усыг ахуйн зориулалтаар ашиглах үйл ажиллагааг зохион байгуулах, үер усны эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг хариуцан гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар мөн.

1.2.Газар нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Гамшгаас хамгаалах тухай, Хот байгуулалтын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай, Зөрчлийн тухай, Хөдөлмөрийн тухай хуулиуд болон бусад холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн тушаал, албан даалгавар болон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

1.3.Газрын үндсэн зорилго нь дүрмийн 1.1-д заасан үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, норм стандартад нийцүүлэн хийж гүйцэтгэх замаар Улаанбаатар хотын хот нийтийн аж ахуй, шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.

1.4.Газар нь тогтоосон журмын дагуу хийгдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэж, банканд харилцах данстай байна.

ХОЁР.УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2.1.Байгууллагын үйл ажиллагааг чиглүүлэх, нийслэлийн хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, зөвлөх үүрэг бүхий Удирдах зөвлөлтэй байна.

2.2.Удирдах зөвлөлийн гишүүдийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн саналыг үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр томилж, чөлөөлнө.

2.3.Удирдах зөвлөл нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 54 дүгээр тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн ажиллах журам"-д заасны дагуу ажиллана.

2.4.Газрын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хэвийн үйл ажиллагааг хангаж, хяналт тавих үүргийг Газрын дарга хэрэгжүүлнэ.

2.5.Газрын даргыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, Улаанбаатар хотын ерөнхий менежертэй зөвшилцөж томилж, чөлөөлнө.

2.6.Газрын дарга нь төрийн байгууллагын удирдах зөвлөл, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөлд орох, тэдгээрийн захиргааны буюу олон нийтийн болон шашны байгууллага, сангийн удирдах ажлыг хавсран гүйцэтгэхийг хориглоно.

2.7.Газар нь үйл ажиллагаагаа Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, Улаанбаатар хотын ерөнхий менежер, Удирдах зөвлөлийн удирдлага дор явуулж, ажлаа тайлагнана.

2.8.Газрын дүрэм, бүтэц, орон тооны дээд хязгаарыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч батална.

2.9.Газрын хариуцан ажиллах гудамж, зам талбайн хуваарийг Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн тушаалаар батална.

2.10.Газрын дарга нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай үр дүнгийн гэрээ болон контракт гэрээг байгуулж биелэлтийг Улаанбаатар хотын ерөнхий менежерийн саналыг үндэслэж дүгнэнэ.

2.11.Газрын дарга нь эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргана.

2.12.Газрын дарга нь дор дурдсан эрх, үүрэгтэй байна;

2.12.1.холбогдох хууль тогтоомжийн хүрээнд, үйлдвэрийн газрын стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;

2.12.2.гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, удирдаж буй үйлдвэрийн газрын хэвийн үйл ажиллагааг хангасны үндсэн дээр санхүү, төлбөрийн чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах;

2.12.3.газрын эрх ашгийг дээдэлж, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан ажиллах;

2.12.4.удирдлагын бүтэц, зохион байгуулалтын хүрээнд хөдөлмөрийн дотоод журам, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажилд авах, хууль тогтоомжийн хүрээнд ажлаас чөлөөлөх;


2.12.5.газрын шинээр худалдан авах болон акталж устгах, худалдах, шилжүүлэх, үндсэн хөрөнгийн асуудлыг Нийслэлийн Өмчийн харилцааны асуудал эрхэлсэн газарт уламжилж шийдвэрлүүлэх;

2.12.6.хууль тогтоомж болон гэрээгээр олгосон бусад эрх, үүргийг хэрэгжүүлэх;

ГУРАВ.ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

3.1.Газар нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн хөгжлийн тухайн жилийн төлөвлөгөө, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн тушаал, шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллана.

3.2.Инженерийн бэлтгэл арга хэмжээ, өндөржилт төлөвлөлтийн чиглэлээр дараах ажил үйлчилгээг гүйцэтгэнэ.



3.2.1. Нийслэлийн үерийн хамгаалалтын далан, суваг, нийтийн аж ахуй, түүний барилга байгууламж, бохир усны төвлөрсөн цэвэрлэх байгууламж, хөрсний усны түвшин доошлуулах болон авто замын борооны ус зайлуулах, шугам сүлжээ, хөв цөөрөм, усан сан төлөвлөх, нэгдсэн мэдээллийн санг үүсгэх, зураг төсөв, ТЭЗҮ боловсруулахад санал, зөвлөмж тусгах, техникийн нөхцөл олгох;

3.2.2. Барилга байгууламж, гудамж зам талбайн өндөржилт, геодезийн сүлжээг мөрдүүлэх, хяналт тавих;

3.3. Үерийн хамгаалалтын далан, суваг, түүний барилга байгууламж, хөрсний усны түвшин доошлуулах болон авто замын борооны ус зайлуулах шугам сүлжээний чиглэлээр дараах ажил үйлчилгээг гүйцэтгэнэ.

3.3.1. Нийслэлийн үерийн хамгаалалтын далан, суваг, түүний барилга байгууламж, хөрсний усны түвшин доошлуулах болон авто замын борооны ус зайлуулах шугам сүлжээ, хөв цөөрөм, усан сан шинээр барьж байгуулах, бүртгэлжүүлэх, цэвэрлэгээ үйлчилгээ хийх арчлан хамгаалах, сэргээн засварлах;

3.3.2. Байгалийн гол, горхи, булаг шандыг тохижуулах, урсац тохируулгатай болгох;

3.3.3. Авто замын борооны болон хөрсний ус татан зайлуулах өргөлтийн насос станцын ашиглалт, засвар үйлчилгээ, хэвийн ажиллагааг хангаж ажиллах;

3.3.4. Хөрсний болон гадаргын усыг ашиглан хиймэл нуур, цөөрөм, амралт зугаалгын цогцолбор байгуулах, үйлдвэрлэл, аж ахуйн хэрэгцээнд ашиглах, цэвэршүүлэх ажлыг зохион байгуулах;

3.4. Инженерийн бэлтгэл арга хэмжээний хамгаалалтын зурвас, Гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах ажил үйлчилгээг гүйцэтгэнэ.

3.4.1. Нийслэлийн үерийн хамгаалалтын далан, суваг, түүний барилга байгууламж, хөрсний усны түвшин доошлуулах болон авто замын борооны ус зайлуулах, шугам сүлжээний хамгаалалтын зурвас дэглэм сахиулах, шугам сүлжээний хэвийн үйл ажиллагаа, бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдэд албадан шаардлага тавих, нөхөн сэргээх, засварлуулж ажиллах;

3.4.2. Уруйн үер, гадаргын үер, газрын доорх буюу хөрсний усны үерийн үед ажиллах Гамшгийн бэлэн байдлын төлөвлөгөөг жил бүр шинэчлэн боловсруулан батлуулж, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед шаардлагатай багаж хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжийн техник, ажиллах хүчний бэлэн байдлыг хангаж ажиллах;

3.4.3. Үерийн эрсдэлтэй бүсэд байрлах нэгж талбарыг чөлөөлөх ажлын хүрээнд жил бүрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал хүргүүлж тусгуулж ажиллах;

3.5. Төсвийн болон өөрийн хөрөнгөөр худалдан авсан түүхий эд материал, бараа, бүтээгдэхүүн, эд хөрөнгө, тоног төхөөрөмжийг хадгалж хамгаалан бүртгэлжүүлнэ.

3.6. Машин механизм, техник тоног төхөөрөмжийн материаллаг баазыг сайжруулах, өргөтгөх, хүчин чадлыг бүрэн ашиглах, тусгай зориулалтын шинэ техник, технологийг нэвтрүүлж ажиллана.

3.7. Үер усны гамшиг, аюул эрсдэлийн чиглэлээр мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй хамтран ажиллаж сургалт зохион байгуулна.

3.8. Өөрийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолын төсөл, Нийслэлийн Засаг даргын захирамжийн төсөл санаачлах, Ерөнхий менежерээр уламжлуулж шийдвэрлүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлж тайлагнана.

3.9. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан үйлчилгээний үнэ тарифыг мөрдөж ажиллана.

3.10. Ашиглалт, засвар үйлчилгээ, хөрөнгө оруулалтын ажилд шаардагдах түүхий эд материал, тоног төхөөрөмжийг гадаад, дотоодын зах зээлээс нийлүүлэх, худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. ГАЗРЫН САНХҮҮ, БҮРТГЭЛ, ТАЙЛАН

4.1. Газар нь санхүүгийн тайланг Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Олон Улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу хуулийн хугацаанд гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулна.

4.2. Газрын санхүүгийн тайлангийн үнэн зөвийг захирал, нягтлан бодогч нар хариуцна.

4.3. Газрын орлого нь дараах санхүүгийн эх үүсвэрээс бүрдэнэ;

4.3.1. нийслэлийн төсвийн санхүүжилт;

4.3.2. орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө;

4.3.3. ажил, үйлчилгээнээс олсон орлого;

4.3.4. байгууллагатай хамтарч ажиллах гэрээний дагуу олсон үйлчилгээний орлого;

4.3.5. хандивлагч орнуудын зээл, тусламж болон төсөл хөтөлбөр, буцалтгүй тусламж;

4.3.6. хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн бусад эх үүсвэр;

4.4. Санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана;

4.4.1. баланс;

4.4.2. үйл ажиллагааны үр дүнгийн тайлан;

4.4.3. мөнгөн гүйлгээний тайлан;

4.4.4. өмчийн өөрчлөлтийн тайлан;

4.4.5. цалин, шагнал, урамшуулал;

4.4.6. нэмэлт тайлбар;


4.4.7. санхүүгийн тайлангийн тодруулга;

4.4.8. бусад;

4.5. Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2-д заасны дагуу хариуцсан чиглэлийн хүрээнд тухайн жилд хийгдэх ажлын жагсаалтыг байгууллагын үр дүнгийн гэрээнд жил бүр тусгаж өгнө.

4.6. Газрын санхүүгийн тайлангийн жил нь тухайн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болно.

4.7. Газрын ерөнхий нягтлан бодогч нь мэргэжлээрээ таваас дээш жил ажилласан, мэргэшсэн нягтлан бодогч байна.



ТАВ.ГАЗРЫН ЭД ХӨРӨНГИЙН ЭРХ

5.1.Газар нь эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй байна;

5.1.1.эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийг дүрэмд заасан үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмших, ашиглах;

5.1.2.эд хөрөнгийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс контракт гэрээгээр олгосон эрх хэмжээний дотор захиран зарцуулах;

5.1.3.төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16.1.3-т заасны дагуу үйлдвэрийн үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас эрх бүхий байгууллагаас баталсан нормативд хэмжээгээр өөртөө үлдээж захиран зарцуулах;

Зургаа.Газрын бичиг баримтыг хадгалах

6.1.Газар нь дараах бичиг баримтыг хадгална;

6.1.1.газрын дүрэм, түүнд орсон нэмэлт өөрчлөлт, холбогдох газруудын шийдвэр, тогтоол, улсын бүртгэлийн гэрчилгээ болон бусад баримт бичиг;

6.1.2.санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, аудитын дүгнэлт, зөвлөмж;

6.1.3.анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт, эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох бичиг баримт;

6.1.4.үйлдвэрлэл, технологи, норм норматив, түүнтэй холбогдох дүрэм, журам, заавар;

6.1.5.тушаал шийдвэр, хурлын тэмдэглэл;

6.1.6.тухайн байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуух баримт бичиг, тусгай төрлийн баримт бичиг;

Долоо.Газрын татан буулгах, өөрчлөн байгуулах

7.1.Газрын Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн саналаар Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Иргэний хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал өөрчлөх, татан буулгах асуудлыг шийдвэрлэнэ.

...оОо...

